




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# БОЛОВСРОЛ 2023



Улаанбаатар  
2024он

## БОЛОВСРОЛЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ:** 2023-2024 оны хичээлийн жилд Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 660 байгууллага үйл ажиллагаа явуулж байснаас 132 (20.0%) нь Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байршин үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс: 38 нь төрийн өмчийн, 94 нь хувийн цэцэрлэг байна. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 132 цэцэрлэгийн үндсэн бүлэгт 25195 хүүхэд хамрагдан хүмүүжиж байгаа бөгөөд өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо 2055-оор өссөн байна. Нийт 1655 багшаас 877 (53.0%) нь үндсэн багш, 778 (47.0 %) нь туслах багш байна.


ХҮСНЭГТ 1. СУРГУУЛЫН ӨМНӨХ БОЛОВСРОЛ-ын байгууллагын зарим үзүүлэлт

| Үзүүлэлт                | 2019-2020 | 2020-2021 | 2021-2022 | 2022-2023 | 2023-2024 |
|-------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| СӨБ-ын байгууллагын тоо | 126       | 126       | 127       | 121       | 132       |
| СӨБ-ын хамтрагчдын тоо  | 18627     | 17491     | 18273     | 23140     | 25195     |
| Үндсэн багшийн тоо      | 606       | 690       | 656       | 832       | 877       |

ЗУРАГ 1. СУРГУУЛЫН ӨМНӨХ БОЛОВСРОЛ-ын байгууллагын тоо



ЗУРАГ 2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ-ын байгууллагад хамрагдагчид




2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 118.2 хувьтай байна. Нийт СӨББ-д хамрагдагчдын 12381 нь эмэгтэй хүүхэд байна.

ХҮСНЭГТ 2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ-ын байгууллагын бүлгийн тоо, 2023/2024 онд

| Бүгд              | Үүнээс:     |      |      |      |       |         |         |
|-------------------|-------------|------|------|------|-------|---------|---------|
|                   | Бүлгийн тоо | Ясли | Бага | Дунд | Ахлах | Бэлтгэл | Холимог |
|                   | 836         |      | 170  | 214  | 221   | 211     | 20      |
| Төрийн өмчийн     | 461         |      | 95   | 121  | 120   | 123     | 0       |
| Төрийн өмчийн бус | 375         |      | 75   | 93   | 101   | 88      | 20      |

ЗУРАГ 3. СӨББ-д ажилладаг үндсэн багшийн тоо



Хан-Уул дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 877 үндсэн багш ажиллаж байгаагаас үндсэн нэг багшид 28,7 хүүхэд ноогдож байна.


**Бага, дунд боловсрол:** 2023-2024 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 61 сургуульд 61418 хүүхэд суралцаж байгаагаас эмэгтэй 30426 хүүхэд суралцаж байна. Өнгөрсөн оны хичээлийн жилтэй харьцуулахад суралцагчдын тоо 6055 (10.9 %) хүүхдээр нэмэгдсэн байна.

2023-2024 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуульд нийт 6539 хүүхэд 1-р ангид шинээр ангид элсэн орсон нь өнгөрсөн оныхтой харьцуулвал 277 (4.1 %) хүүхдээр буурсан байна. 1-р ангид шинээр элсэн орсон нийт хүүхдийн 3208 (49.0%) нь эмэгтэй хүүхэд байна.


ХҮСНЭГТ 3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ-ын сургуулийн зарим үзүүлэлт

| Үзүүлэлт           | 2019-2020 | 2020-2021 | 2021-2022 | 2022-2023 | 2022-2023 |
|--------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| ЕБС-ийн тоо        | 39        | 43        | 47        | 55        | 61        |
| Суралцагчдын тоо   | 35926     | 40757     | 47755     | 55363     | 61418     |
| Үндсэн багшийн тоо | 1694      | 1934      | 2259      | 2553      | 2814      |

ЗУРАГ 4. ЕБС-ийн тоо, төрийн бус сургуулийн тоо



ЗУРАГ 5. ЕБС-д суралцагчдын тоо, эмэгтэй



Сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт хүн ам шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой дүүргийн ЕБС-д суралцагчдын тоо жил ирэх тусам өсч байна. 2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-д суралцагчдын тоо өмнөх оноос 6055 (10.9 %) хүүхдээр өссөн байна. Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчдын 32940 хүүхэд I-V анги, 19535 нь VI-IX анги, 8943 хүүхэд ахлах буюу X-XII ангид суралцжээ.


ЗУРАГ 6. ЕБС-ийн үндсэн багшийн тоо, сургуулийн өмчийн төрлөөр



2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-д ажиллаж байгаа үндсэн багш 2814 байгаагаас 1633 нь төрийн өмчийн сургуульд, 1181 нь төрийн бус өмчийн сургуульд ажиллаж байна. Үндсэн багшийн

тоо өмнөх онтой харьцуулахад 261-өөр өссөн байна. Хан-Уул дүүргийн ЕБС-ийн нэг үндсэн багшид 21.8 хүүхэд ногдож байна.

ЗУРАГ 7. ЕБС-ийн түвшин



Багш нарын боловсролын мэргэжил дээшлүүлсэн байдлыг авч үзэхэд 2023-2024 оны хичээлийн жилд нийт үндсэн багш нарын 0.2 хувь нь доктор, 19.3 хувь нь магистр, 68.3 хувь нь бакалавр, 6.5 хувь нь дипломын боловсрол, 5.8 хувь нь бусад багш нар тус тус эзэлж байна. Мөн ЕБС-ын үндсэн багш нарын 1067 (37.9%) нь мэргэжлийн зэрэгтэй байгаа бөгөөд 1.1 хувь нь зөвлөх, 17.2 хувь нь тэргүүлэх, 19.7 хувь нь заах арга зүйч зэрэгтэй байна. 2022-2023 оны хичээлийн жилд Үндэсний хэмжээнд 56 сургагч багш мэргэжил дээшлүүлсэн байна. 2023-2024 оны хичээлийн жилд Үндэсний хэмжээнд 121 сургагч багш мэргэжил дээшлүүлсэн байна.

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Н.Болор-Эрдэнэ